


10-Р АНГИЙН ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Хугацаа 60 минут

1. Торлолын шугамын хоорондох өнцөг өөрчлөгдөж байвал гажилт үүснэ. \1 оноо\
 - A. Талбайн
 - B. Өнцгийн
 - C. Уртын
 - D. Хэлбэрийн
2. Дэлхий нарнаас ямар зайд оршдог вэ? \1 оноо\
 - A. 100 сая км
 - B. 150 сая км
 - C. 120 сая км
 - D. 200 сая км
3. Наранд хамгийн ойр орших гарагууд аль нь вэ? \1 оноо\
 - A. Буд сугар
 - B. Ангараг, буд
 - C. Сугар, Ангараг
 - D. Сугар, Санчир
 - E. Буд, Дэлхий
4. Дараах байгалийн нөхцөл байдлаас алинд нь хүн ам ихээр суурьших вэ? \1 оноо\
 - A. Өндөр уулархаг газар
 - B. Далайн эрэг орчмоор
 - C. Эх газрын төвд
 - D. Хойд туйлд
5. Өгөршлийг дотор нь,, гэж ангилна. \1 оноо\
 - A. Зөөгдлийн, хуримтлаг, хурдсын
 - B. Физик, Хими, Органик
 - C. Физик, хими, органик бус
 - D. Чулуулгийн, Амьд биесийн
6. Евразийн хамгийн өндөр цэг \1 оноо\
 - A. Климанджаро
 - B. Мак Кинли
 - C. Аканкагуа
 - D. Хүйтэн
7. Газар хөдлөлтийг ямар нэгжээр хэмждэг вэ? \1 оноо\
 - A. Цельс
 - B. Магнитуд
 - C. Паскалл
 - D. Мм м.у.б
8. Хийн мандлын найрлагын ихэнх хувийг эзлэх элемент \1 оноо\
 - A. Хүчилтөрөгч
 - B. Аргон
 - C. Азот
 - D. Устөрөгч
9. Дараах гадаргуудаас хамгийн их альбедотойг сонгоно уу? \1 оноо\
 - A. Шинэ цас
 - B. Хар зам
 - C. Үүл
 - D. Мөс
10. Агаарт тухайн үед бэлэн оршиж буй усны уурын хэмжээг гэнэ. \1 оноо\
 - A. Харьцангуй чийг
 - B. Үнэмлэхүй чийг
 - C. Чийгийн багтаамж
 - D. Чийг
11. Далайн усны дундаж давсжилт хэд вэ? \1 оноо\
 - A. 17 ‰
 - B. 25‰
 - C. 35‰
 - D. 45‰
12. Бүх төрлийн амьд бүрхэвчийн амьдардаг газарзүйн бүрхэвчийн хүрээ нь юм \1 оноо\
 - A. Биомандал
 - B. Биологи
 - C. Экосистем
 - D. Географи
13. Хойд туйлын зураг гаргахдаа ямар тусгаг ашиглавал тохиромжтой вэ? \2 оноо\
 - A. Азимут
 - B. Меркатор
 - C. Цилиндр
 - D. Конус



14. Монгол орны нутаг дэвсгэрийн бүтэн зураг ямар тусгагаар ихэвчлэн зурагддаг вэ? \2 оноо\
 - A. Азимут
 - B. Меркатор
 - C. Цилиндр
 - D. Конус
15. Улирал солигддогын шалтгаан юу вэ? \2 оноо\
 - A. Дэлхий тэнхлэгээ эргэдэг
 - B. Дэлхий нарыг тойрдог
 - C. Дэлхий 2 туйлаараа ээлжлэн нарлуу хардаг
 - D. Дэлхийн тэнхлэг хазгай нарыг тойрдог
16. Дэлхий нарыг тойрох орбитын 940 сая км замыг 365 хоног 5 цаг 49 минутанд туулдаг бол дэлхийн нарийг тойрох хурд хэд байх вэ?
 - A. 30км/сек
 - B. 300км/ с
 - C. 80 км/с
 - D. 45 м/с
17. 6-р сарын 22-ны өдөр Монгол оронд хамгийн урд өдөр тохиодог бол энэ өдөр Ө.Ө 40 орших нутагт ямар өдрүүд тохиох вэ? \2 оноо\
 - A. 30км/сек
 - B. 300км/ с
 - C. 80 км/с
 - D. 45 м/с

А. Өдөр шөнө тэнцэнэ В Хамгийн урт өдөр С Хамгийн богино өдөр D. Хамгийн халуун өдөр

18. Хүн ам оршин суух нөлөөлөх хүчин зүйлсийг ол. \2 оноо\

А. Тааламжтай уур амьсгал, үржил шимтэй хөрс, голын хөндий

В. Далайн урсгал, газрын баялаг, хүйтэн уур амьсгал

С. Газрын баялаг, сэрүүн уур амьсгал, үржил шимтэй хөрс

D. Голын хөндийн, сэрүүн уур амьсгал, өндөрлөг газар

19. Экзоген үйл явц гэж алийг хэлэх вэ? \2 оноо\

А. Хүлэрийн үе В. Манан үүсэх С. Чулуулаг бутрах D. Галт уулшил

20. Чулуулаг эвдрэн бутрах үйл явц нь \2 оноо\

А. Физик өгөршил В. Хими өгөршил С. Органик өгөршил D. Халууны өгөршил

21. Галт уул дэлбэрэх, тектоникийн хөдөлгөөнд ямар үелэл гол үүрэгтэй вэ? \2 оноо\

А. Газрын давхарга В. Манти С. Цөм D. Астеносфер

22. Аль өгөгдөлд магмын чулуулаг байна вэ? \2 оноо\

А. Гантг, гнейс, талст занар С. Боржин, кварц, хүрмэн чулуу


В. Гөлтгөнө, асфальт, хүлэр, нүүрс D. Элс, шаварлаг занар, чулуун нүүрс

23. Баруун Европын зөөлөн уур амьсгалыг юугаар тайлбарлах вэ? \1 оноо\

А. Өргөргийн байрлал С. Уртрагийн байрлал

В. Тэнгис далайд ойр D. Ойн эзлэх талбай бага

24. Дараах зурагд ямар төрлийн тунадасыг харуулсан байна вэ? \1 оноо\



А. Конвекцийн тунадас

В. Фронтын тунадас

С. уулзүйн тунадас

D. Хур тунадас

25. Агаарын даралт их байвал цаг агаар ямар шинжтэй болох вэ? \1 оноо\

А. Тэнгэр бүрхэг, Хур тунадастай

В. Тэнгэр цэлмэг, хур тунадасгүй

С. Тэнгэр бүрхэг, хур тунадасгүй

D. Салхи ихтэй, цас орно

26. Салхи үүсэн шалтгаан нь юу бэ? \1 оноо\

А. Кориолисийн хүч В. Агаарын даралтын зөрүү

С. Дэлхийн эргэлт D. Нар сарны татах хүч

27. Цаг агаарын мэдээгээр 2023 оны 7-р сарын 16-нд агаарын температур 27°C , хөрсөн дээр 35°C хүрч халжээ. Учрыг зөв тайлбарласан өгүүлбэрийг сонго. \1 оноо\

А. Агаар эхэлж халж хөрсийг дараа нь халаана В. Мэдээлэл буруу байна.

С. Хөрс эхэлж халан дараа нь агаар халдаг.

D. Агаарын температур жигд биш байдаг

28. Далайн усны давжилт тропик орчим их байгаа шалтгаан юу вэ? \2 оноо\

А. Хур тунадас их ордог

В. Ууршилт бага

С. Томоохон голууд цутгадаг

D. Хур тунадас ордоггүй

29. Ойд биомасс их байхад цөлөрхөг газар био масс бага байгаа шалтгаан \2 оноо\

А. Цөл газар их халдаг

В. Ой модтой газар мод их ургана

С. Ойд амьтан ургамал ихтэй

D. Ойд ус их

30. Өвөлдөө $+10$ градусаас буурахгүй, зундаа $30-35$ градус халдаг дэлхийн томоохон цөлүүд оршдог бүслүүр \2 оноо\

А. Сэрүүн бүслүүр

В. Экваторын бүслүүр

С. Халуун бүслүүр

D. Тундрын бүслүүр

31. Дэлхийн салхины тархалтын зураг хийхээр бол зурагзүйн дүрслэлийн ямар аргыг хэрэглэх вэ? \1 оноо\


- A. Тэмдгийн арга B. Цэгийн арга C. Ареал(Талбай)-н арга D. Хөдөлгөөнт шугамын арга

32. Хүн ам өргөрөгийн дагуу хэрхэн

суурьшсаныг ажиглан хамгийн их хүн ам


амьдарч буй өргөрөгүүдийг нэрлэ. ? \2 оноо\

- A. Х.Ө 20°-Х.Ө 40°
 B. Х.Ө 40°-Х.Ө 60°
 C. Х.Ө 0°-Х.Ө 20°
 D. Ө.Ө 20°-Ө.Ө 40°




33. 1-ын тоогор юуг дүрслэн үзүүлсэн байна вэ? ? \2 оноо\

- A. Арал
 Б. Далайн гол нуруу
 В. Далайн гүн ховил
 Г. Шельеф



34. Дараах зураг чулуун мандалын ямар хүчин зүйлсийг илэрхийлссэн зураг вэ? \2 оноо\

- A. Уул үүсэх үйл явц
 B. Тектоникийн хавтангийн хөдөлгөөн
 C. Чулуулаг эвдрэх, будрах
 D. Далай ба хуурай газрын төрөл



35. Агаарын температур 20° C үед 17,32°С чийгийн багтаамжтай байх бөгөөд тухайн үед үнэмлэхүй чийг 9.41°С бол харьцангуй чийг хэд байх вэ? \2 оноо\

- A. 30.9 % B. 50% C. 78.5% D. 54.3%

36. Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар аль нь вэ?

- A. Аж үйлдвэрлэл эрчимжих B. CO₂ ялгаруулалт нэмэгдэх
 C. Мөстлөг мөсөн гол хайлах D. Галт уулын идэвхжил нэмэгдэх


37. Европын баруун эргийн уур амьсгалд нөлөө үзүүлэх далайн дулаан урсгалыг сонгоно уу?

\2 оноо\



- A. Канарын урсгал
 B. Хойд Пассат урсгал
 C. Гольфстрим урсгал
 D. Перугийн урсгал

38. Чулуун мандлын хавтангууд болон хавтангуудын хөдөлгөөний төрлүүдийг харуулсан зургийг ашиглан дараах асуултуудад хариулаарай.



А. Галт уулсын байршил ба хавтангуудын хамаарлыг дүгнээрэй.

.....


.....

.....

Б. Зургийг ашиглан хүснэгтийг нөхөөрэй.

Хавтангийн нэр	Хөдөлгөөний төрөл
Евразийн болон Энэтхэг-Австралийн	
Евразийн болон Хойд Америкийн	

39. Хотуудын уур амьсгалын диаграмм ажиглаж дараах дасгалыг гүйцэтгээрэй. /4 оноо/



- А. Хамгийн их хур тунадас орсон газар
- Б. Хамгийн их халдаг хот
- В. Агаарын температурын хэлбэлзэл ихтэй хот
- Г. 5-8-р сард хур тунадас ордоггүй хотыг нэрлэ.

40. Улз гол д.т.д 1100м-с эх авч 400 гаруй км урссаар д.т.д 720м Тарь нуурт цутгана. Дунджаар 1.4 м гүн, 6м өргөн, 1.2м/с бол голын унал болон зарцуулгыг олно уу? \3 оноо\

Голын унал.....

Голын усны зарцуулга